



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулж, удирдамж
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”, “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам”, 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрмийн 3.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Соёлын төв өргөөний түрээсийн үйл ажиллагаа, барилга байгууламж, байр талбай болон эд хөрөнгийн хөдөлгөөн, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт, шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүний нэгдүгээр хавсралтаар, шалгалтын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх ажлыг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэн, холбогдох санал дүгнэлт гаргаж, 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /М.Мандах/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч даргын үүрэг гүйцэтгэгч /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.


ДАРГА



М.БАЯРАА

115050000009


Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 12 -ны
өдрийн 01 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	М.Мандах	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн дарга
Гишүүд:	Ж.Сувданзаяа	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Батаа	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн өмчийн ашиглалт хариуцсан мэргэжилтэн
	Б.Эрдэнэмөнх	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн өмчийн ашиглалт хариуцсан мэргэжилтэн
	Т.Оюунсүвд	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн хөрөнгийн бүртгэл, орлого хариуцсан мэргэжилтэн
	О.Уранчимэг	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн байр ашиглалт, түрээс хариуцсан мэргэжилтэн
	Г.Уранцэцэг	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн
Ажлын хэсгийн нарийн бичиг:	Ц.Цолмон	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2021 оны 21 дүгээр сарын 12 -ны
өдрийн 1/02 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ БАРИЛГА
БАЙГУУЛАМЖ, БАЙР ТАЛБАЙ БОЛОН ЭД ХӨРӨНГИЙН
ХӨДӨЛГӨӨН, АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТАД
ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Нийслэлийн Соёлын төв өргөөний түрээсийн үйл ажиллагаа, барилга байгууламж, байр талбай болон эд хөрөнгийн хөдөлгөөн, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт, шалгалт хийх, зөрчил дутагдлыг арилгах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөмж өгөхөд шалгалтын зорилго оршино.

Хоёр. Эрх зүйн үндэс

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”, 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”, “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам”, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрмийн 3.4 дэх хэсэг тус тус эрх зүйн үндэс болно.

Гурав. Хамрах хүрээ, шалгалтын үйл ажиллагаа

1. Түрээсийн үйл ажиллагааны хэрэгжилтийг шалгах:

- Илүүдэлтэй байр, талбайг түрээслүүлэхдээ Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын зөвшөөрөл авсан, түрээсийн гэрээ байгуулан баталгаажуулсан эсэх,
- Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулалт явуулж зонгосон эсэх,

- Барилга байгууламжийн илүүдэлтэй байр, талбайг түрээсийн гэрээнд заасан зориулалт, талбайн хэмжээгээр эзэмших байгаа эсэх,
- Түрээсийн төлбөр тооцоо нийлсэн байдал,
- Бусдад дамжуулан түрээсэлсэн эсэх,
- Эд хөрөнгийг түрээсээр эзэмших хугацаандаа түүний бүрэн бүтэн байдал, урсгал засварын хариуцах, сонгон шалгаруулалтад тавигдсан шаардлагын дагуу ашиглалтыг сайжруулсан байдал зэргийг газар дээр нь шалгах

2. Эд хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэл болон барилга, байгууламжийн ашиглалт, хамгаалалтын байдлыг шалгах

Дөрөв. Ажиллах, тайлагнах хугацаа

Шалгалтын ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 19-ний өдөр хүртэл хугацаанд явуулж, тайланг 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн дотор гарган танилцуулна.